НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАР БА ХУДАЛДААНЫ АЛБАН ТАТВАР, ТЭДГЭЭРИЙН ОНЦЛОГ, ДАВУУ БОЛОН СУЛ ТАЛ

(Харьцуулсан судалгаа)

Ц.Норовдондог, Г.Билгээ,
Ч.Онончимэг, Ц.Элбэгзаяа

АГУУЛГА

Оршил

Судалгааны үр дүн

1. НӨАТ болон худалдааны татвар хоорондын ялгаатай ойлголт ба зохицуулалт

2. Гадаадын зарим орны НӨАТ болон худалдааны татварын эрх зүйн зохицуулалт
   2.1. Австрали /НӨАТ-Бараа ажил үйлчилгээний татвар/
   2.2. Индонези /НӨАТ/
   2.3. Казахстан /НӨАТ/
   2.4. Канад /НӨАТ-Бараа үйлчилгээний татвар/
   2.5. Нидерланд /НӨАТ/
   2.6. ОХУ /НӨАТ/
   2.7. БНХАУ /НӨАТ/
   2.8. Чили /НӨАТ/
   2.9. АНУ /Худалдааны татвар/
   2.10. Энэтхэг /НӨАТ, Худалдааны татвар/

Хүснэгт 1. Дэлхийн улс орнуудад мөрдөж буй татварын төрөл, хувь хэмжээ

Ашигласан материал

ОРШИЛ

Судалгааны зорилго

Энэхүү судалгаагаар шууд бус татварын нийтлэг хувилбар болох Нэмэгдсэн өртгийн албан татвар болон Худалдааны татварын хувь хэмжээ, эрх зүйн зохицуулалт, эдгээр татваруудын хоорондын ялгаа, давуу болон сул тал зэргийг онолын ойлголт, зарим орны туршлага, олон улсын чиг хандлагад тулгуурлан харьцуулан судалсан болно.

Судалгааны хамрах хүрээ

Судалгаанд:

- НӨАТ-ын системтэй орнууд: Индонези, Казахстан, Канад, Нидерланд, ОХУ, БНХАУ
- НӨАТ-Бараа ажил үйлчилгээний татвартай орнууд: Австрали, Чили
- Худалдааны татвартай орнууд: АНУ, Энэтхэг зэрэг орнуудыг сонгон авч татварын эрх зүйн зохицуулалтыг судалсан болно.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн хүрээнд 1993 оноос Худалдааны татварыг нэвтрүүлж, 1998 оноос Нэмэгдсэн өртгийн албан татвар /НӨАТ/ болгон өөрчилсөн түүхтэй. Судалгааны ажлыг гүйцэтгэхдээ Ernst & Young Их Британий олон улсын Аудит-консалтинг компаниас[92] 2013 онд дэлхийн 150 гаруй орны татварын системийн талаар гаргасан лавлагаа мэдээллээс[93] суурь мэдээллээ авсан бөгөөд үүнийг үндэслэн НӨАТ-ыг сонгодог утгаар нь нэвтрүүлсэн, цогц системтэй орнуудын төлөөлөл болгож Индонези, Казахстан, Канад, Нидерланд, ОХУ, БНХАУ-ыг, уул уурхайн салбар амжилттай хөгжсөн орнуудын төлөөлөл болгож Австрали, Чили улсуудыг, худалдааны татвартай орнуудын төлөөлөл болгож АНУ, Энэтхэг зэрэг орнуудыг сонгон авч судалсан болно. Дээрх мэдээллээс үзэхэд, дэлхийн ихэнх улс НӨАТ-ыг хэрэглэж байгаа бөгөөд татварын систем дэх шууд бус татварын чухал төрөл болох нь харагдаж байна.

Түүнчлэн Олон Улсын Валютын Сан (IMF)-гаас гаргасан мэдээллээр, дэлхийн 140 гаруй улс НӨАТ-ыг нэвтрүүлэн мөрдөж байгаа бөгөөд энэхүү татварын төрөл нь гадаад худалдаа, гадаадын хөрөнгө оруулалтад сөрөг нөлөөгүй, destination principle буюу экспортод тэг хувиар татвар ногдуулж, импортод үндсэн хувь хэмжээгээр татвар ногдуулдаг зарчим нь гадаад худалдааны олон талт гэрээ хэлцэл, Дэлхийн худалдааны байгууллагын нийтлэг зарчимд нийцэж байна[94] хэмээн дүгнэсэн байдаг.

Дээрх судалгаануудаас үзэхэд, дэлхийн улс орнуудын Засгийн газрууд НӨАТ-ыг төсвийн орлого бүрдүүлэх томоохон арга хэрэгсэл хэмээн үзэж, татварын системдээ нэвтрүүлсэн нь харагдаж байна. Цөөн улс орныг эс тооцвол НӨАТ-ын систем нь стандарт тогтолцоотой бөгөөд хөрш орнууд болон эдийн засгийн төстэй бүтэцтэй зарим орны хувьд манай орны нөхцөлд тохирохуйц нэг талаас төсвийн орлогыг нэмэгдүүлэх, нөгөө талаас татвар төлөгчдөд учирч буй дарамтыг бууруулах сонирхолтой туршлагууд ажиглагдаж байна. /судалгаанаас үзнэ үү/

Онолын хувьд авч үзвэл, нэмэгдсэн өртгийн албан татвар бол шууд бус татварын арга хэрэгсэл юм. ***Шууд татвар нь*** хүн ам, үйлдвэрийн газар, байгууллагын мөнгөн орлогод оногдуулдаг, ямар нэгэн борлуулалт, ажил үйлчилгээгээр дамжуулахгүйгээр авч байгаа татвар бол ***шууд бус татвар нь*** үнийн нэмэгдлийн хэлбэрээр илэрхийлэгдэж, хэрэглэгчдийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үед ногдуулж, борлуулагчаар дамжин хэрэглэгчдийн өмнөөс төсөвт төлөгддөг татвар юм. Дэлхийн бусад улс орнуудад борлуулалтын татвар, худалдааны татвар, жижиглэнгийн худалдааны татвар, гүйлгээний татвар, НӨАТ, онцгой татвар гэх мэтийн олон төрлийн нэр, зорилт бүхий хэрэглээний татваруудыг авч байна. Нэршлийн хувьд Нэмэгдсэн өртгийн албан татварыг НӨАТ (value added tax), хэрэглээний татвар (consumption tax), бараа үйлчилгээний татвар (goods and service tax) гэх мэтээр нэрлэж байна[95].

НӨАТ ба Худалдааны татварууд нь өөрийн гэсэн давуу болон сул талуудтай нь судалгаанаас харагдаж байна. Энэ хоёр татварын аль нэгийг нь сонгох явдал илүү гүнзгий судалгаанд үндэслэх нь ойлгомжтой. Судлаачдын үзэж байгаагаар төр засгаас энэ асуудлыг шийдвэрлэхдээ шинжлэх ухааны тооцооллын дүнг харгалзахгүй, зөвхөн улс төрийн нөлөөгөөр хууль баталж байна гэдэг.[96]

---

[92]Их Британийн Аудитор-Консалтинги компани/ http://ru.wikipedia.org/wiki/Ernst_%26_Young

[93]http://www.ey.com/Publication/vwLUAssets/2013-worldwide-VAT-GST-and-sales-tax-guide/$FILE/2013-worldwide-VAT-GST-and-sales-tax-guide.pdf

[94]John Brondolo, Ron McMorran, Robin Adair, 1999, Mongolia: Improving the design and administration of the VAT IMF-Worldbank

[95]http://www.iltod.gov.mn/?p=1956

[96]НДС или налог с продаж. Зарубежный опыт. Евгений Воловик эксперт, Финансовая газета. http://fingazeta.ru/discuss/49959/

Ерөнхийд нь авч үзвэл, НӨАТ-ын татварын системийг зөв зохион байгуулж чадсан тохиолдолд татварын давхардлаас зайлсхийх, бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн үе шат бүхэнд татвар тооцох, НӨАТ-ыг буцаан олгосноор хямд өртөгтэй бүтээгдэхүүн экспортод гаргах, үйлдвэрлэлийн болон борлуулалтын бүх шатанд татвар ногдуулах гэх мэтийн онцлогууд байх боловч татвар шударга байх, төлөгдөхүйц байх зарчмуудтай зөрчилддөг хэмээн судлаачид үздэг. Ялангуяа НӨАТ-ын татварыг хэрэглээгээр дамжин ногдуулдаг учир орлого багатай, ядуу хэсэгт татварын дарамт үүсгэн үнэ хөөрөгдөх нөхцөл бүрдэнэ. Татвар төлөгчийн төлбөрийн чадвартай уялдаж чаддаггүйгээс өрхийн орлого хуваарилалтад сөргөөр нөлөөлж, хэрэглээг бууруулснаар амьжиргааны түвшинд сөргөөр нөлөөлдөг гэж судаачид үзэж байна.

Худалдааны татварын хувьд, нийлүүлэлтийн сүлжээний үе шат бүхэнд татвар давхардуулан оногдуулах, бараа, үйлчилгээний үнэ өсөх, татварын буцаан олголт хийгдэхгүй учраас экспортлогч компанийн хувь татварын ачаалал нэмэгдэх гэх мэтийн онцлогууд байдаг байна.

НӨАТ манай улсад хэрэгжээд удаагүй ч онолын хувьд ч, судалгааны түвшинд ч төгс боловсронгуй болж чадаагүй байгаа татварын төрөл юм. Өнөөгийн байдлаар дэлхий дээр НӨАТ-ын системийг нэвтрүүлээгүй орнууд ч байна. *Тухайлбал,* дэлхийн өндөр хөгжилтэй орнуудаас АНУ, мөн Багамын арлууд, Бахрейн, Британийн Виржиниа, Бермуд, Бруней, Хонгконг, Макао, Кейманы арлууд, Гибралтар, Гуэрнси, Ирак, Кувейт, Ливи, Малдив, Оман, Катар, Сан-Марино, Саудын Араб, Арабын Нэгдсэн Эмират улс зэрэг 17 улс, автономит мужууд НӨАТ-гүй байгаа бөгөөд тэдгээрээс АНУ болон Арабын орнуудад НӨАТ-ыг нэвтрүүлэх талаар асуудал яригдаж байна.

Нэг. НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАР БОЛОН ХУДАЛДААНЫ ТАТВАР ХООРОНДЫН ЯЛГААТАЙ ОЙЛГОЛТ БА ЗОХИЦУУЛАЛТ

Нэр томьёоны ялгаатай ойлголт:

Эх сурвалж	*НӨАТ*	*Худалдааны татвар*
Dictionary of taxation terms /English-Russian-German-French/ TACIS, First Edition, 1996	***ENG - value added tax; VAT*** Худалдаалж байгаа бараа, үйлчилгээний үнийн дүнгээс хувь тооцож авах, эсхүл импортолж байгаа тодорхой бараа, үйлчилгээний үнийн дүнгээс хувь тооцож авах шууд бус татвар /англи хэлнээс/ ***RU - налог на добавленную стоимость, НДС*** Үйлдвэрлэл, солилцоо, дахин худалдаалах үе шат бүхэнд нэмэгдсэн өртөгт ногдуулдаг татварын систем. Барааны үнэд шингээх замаар шаталсан байдлаар төсөвт шилжүүлэх татвар /орос хэлнээс/	***ENG - sales tax*** Худалдах, худалдан авах гэрээ дуусгавар болоход худалдаалсан бүх барааны үнийн дүнгээс хувь тооцож авах албан татвар /англи хэлнээс/ ***RU - налог с оборота; налог на продаж*** Хэрэглэгчийн худалдан авч байгаа бараа, эсхүл үйлчилгээний үнэд шингэсэн татвар /орос хэлнээс/ Жич: Худалдааны татвар нь орон нутгийн татварын ангилалд хамаарч байна.

Г.Цэрэндагва Эдийн засгийн ухаан УБ-2013 , хуудас 221	***Нэмэгдсэн өртгийн татвар нь*** түүхий эдээс бүтээгдэхүүн хийж хэрэглэгчдэд хүргэх түвшинд нэмж бий болгосон өртгөөс татвар авдаг арга юм. Жишээ нь: улс татвар авахдаа үйлдвэрийн бүтээсэн өртөг, таваарын үнийн завсрын өртгөөс эхлээд, дараа нь бөөний худалдааны байгууллагын үнэ, үйлдвэрлэгчийн үнийн зөрүүгээс, эцэст нь жижиглэн худалдах дэлгүүрийн үнэ, бөөний худалдааны байгууллагын зөрүүгээс татвар тус тус авна.	***Худалдааны татварын нэг төрөл нь нэмэгдсэн өртгийн татвар юм.*** Энэ нь татварыг янз бүрийн аргаар цуглуулах бодлогын нэг жишээ юм. Өөрөөр хэлбэл татварыг бэлэн болсон бараанаас ч эсвэл түүнийг үйлдвэрлэлийн шатанд ч авч болно. Үйлдвэрлэлийн үе шатуудад зөвхөн нэмэгдсэн өртөг нь татвар ногдуулах зарчмаар татвар хураах аргыг нэмэгдсэн өртгийн татвар илэрхийлнэ. Өөрөөр хэлбэл таваарын өртгөөс түүнд оролцсон ногдуулах үйл явц юм. Учир нь анхны түүхий эдийн өртгөөс түүний үйлдвэрлэсэн газарт нь татвар авчихсан учраас үйлдвэрлэлийн дараагийн үе шатанд татвар авахгүй гэсэн санаа юм.
ТЕГ, МУИС-ХЗС, ШУА Монгол Улсын албан татварын эрх зүй УБ-2009	***НӨАТ нь үйлдвэрлэлийн үе шат бүр дээр нэмэгдэн гарч байгаа нэмүү өртгөөс авч байгаа албан татвар юм.*** Нэмүү өртөг /VA/ гэдэг нь зөвхөн тухайн шат дамжлаг дээр гарч байгаа цалингийн зардал /V/ ашгийн /m/ нийлбэр бөгөөд татвар төлөгч зөвхөн түүнд ногдох татвараа төсөвт шилжүүлдгээрээ нэмэгдсэн өртгийн албан татвар нь бусад татвараас ялгаатай.	
Борлуулалтын татвар ба НӨАТ-ын судалгаа http://www.iltod.gov.mn/?p=1956	НӨАТ (**value added tax**) буюу зарим улс оронд хэрэглээний татвар (consumption tax), бараа үйлчилгээний татвар буюу (goods and service tax) гэж нэрлэдэг. Өнөөгийн манай улсад хэрэглэж байгаа татвар нь борлуулалтад ногдсон НӨАТ-аас худалдан авалтдаа төлсөн НӨАТ-ыг хасаж тооцдог тогтолцоо юм. НӨАТ-ын гол онцлог нь татварын дарамтыг хэрэглэгчид үүрэх бөгөөд үйлдвэрлэгчдийн төлсөн татварыг хасалт хийж буцаан олгодог онцлогтой.	Худалдааны татвар буюу (sales tax). Энэ татвар нь НӨАТ-ын тогтолцоотой ойролцоо бөгөөд зөвхөн татвар ногдуулах үйлдвэрлэл үйлчилгээний түвшингөөр ялгагддаг. Үйлдвэрлэлийн худалдааны татвар, бөөний худалдааны татвар, импортын худалдааны татвар гэх зэрэг олон хувилбартай.

- **Нэмэгдсэн өртгийн албан татвар /НӨАТ/**

Бараа, үйлчилгээний хэрэглээнд ногдуулах татварыг нэмэгдсэн өртгийн албан татвар /НӨАТ/ гэх бөгөөд бараанд ногдох НӨАТ-ыг үйлдвэрлэлийн шат дамжлага бүрд ногдуулж, төлж байдаг. Үүнд: түүхий эд, материал худалдан авах, түүнийг боловсруулах, бэлэн бүтээгдэхүүнийг бөөний үнээр нийлүүлэх, жижиглэнгийн худалдаа эрхлэх үйл ажиллагаа зэргийг дурдаж болно. Харин үйлчилгээнд ногдуулах НӨАТ-ыг уг үйлчилгээ эцсийн хэрэглэгчид хүрэх үед ногдуулдаг.

НӨАТ-ын орлого цуглуулах чадварыг (НӨАТ-ын бүтэц, хэрэгжүүлэх аргачлал болон татварын албаны хууль хэрэгжүүлэх чадварыг хамтатган үзүүлэх хэмжигдэхүүн) татварын байр суурь болон татвар төлөгчдийн тоон үзүүлэлт гэсэн хоёр хэмжүүрээр хэмждэг[97].

НӨАТ (**value added tax**) буюу зарим улс оронд хэрэглээний татвар (consumption tax), бараа үйлчилгээний татвар (goods and service tax) гэж нэрлэдэг. Энэхүү татварын хувьд борлуулалтад ногдсон НӨАТ-аас худалдан авалтдаа төлсөн НӨАТ-ыг хасх тооцдог тогтолцоо юм.

Аливаа татвар нь тухайн улс орны төсөв, татварын тогтолцооны нэг хэсэг байж цогц хэлбэрээр хэрэгждэг. НӨАТ нь шууд бус татварын хувьд бусад татваруудтай уялдаатай байдаг. Жишээ нь НӨАТ төлөгчөөр бүртгэгдсэн этгээд нь бусдад төлсөн НӨАТ-аа зардлаар тооцдоггүй байхад НӨАТ-аас чөлөөлөгдсөн этгээд нь түүнийг бараа, ажил үйлчилгээний өртөгт шингээж татвар ногдох орлогоос хасагдах зардалд тооцдог.

Өөрөөр хэлбэл НӨАТ-ын гол онцлог нь татварын дараамтыг хэрэглэгчид үүрэх бөгөөд үйлдвэрлэгчдийн төлсөн татварыг хасалт хийж буцаан олгодог онцлогтой.

Хэрэглээ нь харьцангуй тогтмол шинжтэй, өсөлт бууралтын хэмжээ бага байдгаас НӨАТ-ын төсвийн орлогын “тогтмол эх үүсвэр” гэж үздэг. Ийнхүү татварын орлогын хэмжээ өсөж байгаа нь Монгол Улсын эдийн засаг тэлж, хэрэглээ, гадаад худалдааны эрэлт, хөрөнгө оруулалт өссөнтэй холбоотой юм.

НӨАТ-ын хувьд Засгийн газраас үзүүлдэг нийгмийн халамжийн зориулалттай эрүүл мэнд, боловсрол, нийтийн тээврийн үйлчилгээ, мөн шашны үйлчилгээ, төрийн байгууллагын үйлчилгээ, орон сууц түрээслэх үйлчилгээ, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэглээнд зориулсан тусгай зориулалтын хэрэгсэл, жижиг дунд үйлдвэрийн тоног төхөөрөмж, батлан хамгаалахад зориулсан тоног төхөөрөмжийн импорт гэх мэт бараа ажил үйлчилгээнд татвар ногдуулах нь зохимжгүй байдаг. Төрөөс үзүүлэх үйлчилгээнд НӨАТ ногдуулах нь нийгмийн бодлогод үл нийцэх ба татварын нэмэлт дарамт бий болгож төсвийн зардлыг л нэмэгдүүлнэ гэж үздэг байна.

Мөн түүнчлэн банк, даатгал, үнэт цаас, санхүүгийн салбарын үйлчилгээний НӨАТ ногдох борлуулалтын хэмжээг тодорхойлоход гарах хүндрэлээс шалтгаалан НӨАТ-аас чөлөөлдөг.

Иргэний агаарын тээврийн онгоц, түүний сэлбэг хэрэгсэл, аялал жуулчлал, буцалтгүй болон хүмүүнлэгийн тусламжийн барааг Олон улсын гэрээ конвенц, нийтлэг жишигт үндэслэн татвараас чөлөөлөх ба дипломат төлөөлөгчийн газрууд, экспортын бараа ажил үйлчилгээ, гадаад оронд үзүүлсэн үйлчилгээнд 0 хувиар татвар ногдуулах нь түгээмэл байна.

Нөгөө талаар НӨАТ-аас чөлөөлөгдөж байгаа этгээд нь эцсийн хэрэглэгч гэж тооцогддог. Жишээ нь банкны үйлчилгээ НӨАТ-аас чөлөөлөгддөг. Энэ нь банк өөрийн үйлчилгээний орлогодоо НӨАТ ногдуулахгүй гэсэн утгатай боловч нөгөө талаас хэрэглэгчийн хувьд бүхий л худалдан авалтдаа (дулаан цахилгаан, холбоо, интернэт, ажлын байрны түрээс, тоног төхөөрөмж, програм хангамж гэх мэт) НӨАТ төлдөг. Иймд татвараас чөлөөлөгдөж байгаа хувь хүмүүс, хуулийн этгээдүүд, жижиг бизнес эрхлэгчид нь хэрэглэгчийн хувьд НӨАТ-ын бааз суурийг багасгадаггүй онцлогтой.

[97]Эдгээр үзүүлэлтүүд нь Шинэ Зеланд улсад 65 ба 103 хувьтай байдгаас нь хамгийн шилдэг бүтэцтэй НӨАТ-тай улс гэж тооцогддог байна.

Монгол Улсын хуулиар НӨАТ ногдуулах жишээ[98]



НӨАТ-ын хувь хэмжээ:

НӨАТ-ын хувь хэмжээг улс бүр өөрийн онцлогт тохируулан тогтоох бөгөөд татварын хувь хэмжээ нь 10-25 хувийн хооронд хэлбэлзэж байна. Зарим улс оронд нийгэм, эдийн засгийн нөлөөллөөс нь хамааруулан бараа бүтээгдэхүүнд НӨАТ-ын хэд хэдэн хувь хэмжээг байдгийг дараах хувь хэмжээнээс харж болно. Үүнд:

- Хүнс, эмнэлгийн болон хүүхдийн бараа бүтээгдэхүүнд *бууруулсан* хувь хэмжээг /2-10%/
- *Стандарт буюу үндсэн хувь хэмжээг* /12-23%/ үйлдвэрийн болон бараа үйлчилгээнд
- *Өсгөсөн хувь хэмжээг* /25%-аас дээш/ тансаг хэрэглээний зүйлд ногдуулдгаас тодорхой байна.

Хэд хэдэн улс оронд /Канад, Ирланд, Их Британи, Мексик/ дотооддоо борлуулж байгаа бүлэг бараа, үйлчилгээнд тэг хувь хэмжээг идэвхтэй ашигладаг. Бууруулсан хувь хэмжээг болон тэг хувь хэмжээг ашигладаг бараа, үйлчилгээг дурдвал:

- Сонин хэвлэлд бууруулсан болон тэг хувь хэмжээг бараг бүх улс оронд /Канад, Япон, Шинэ Зеланд, Туркээс бусад/,
- Хүнсний бүтээгдэхүүнд ойролцоогоор 18-23 улс оронд бууруулсан хувь хэмжээг,
- Эмийн бүтээгдэхүүнд ойролцоогоор 11 улс,
- Олон нийтийн тээврийн хэрэгсэлд 10 гаруй,
- ХАА-н хүнсний бүтээгдэхүүнд бараг бүх улс орон хөнгөлөлттэй хувь хэмжээг хэрэглэж байна.

Гэвч олон улсын жишгээс харахад цаашдаа нэгдсэн нэг хувь хэмжээг хэрэглэх чиг хандлага харагдаж байна. Учир нь олон хувь хэмжээг хэрэглэх нь татвар хураахтай холбоотой зардлыг нэмэгдүүлдэг, өсгөсөн хувь хэмжээ нь тухайн барааны эрэлтийг бууруулж орлого хуваарилахад сөрөг нөлөөг үзүүлдэг, бууруулсан хувь хэмжээг бүх

[98]www.mongoltax.mn

түвшний хэрэглэгчид адил түвшинд хүртдэг учир орлогын хуваарилалтыг хүссэн үр дүн гардаггүй гэх мэт шалтгаантай.

НӨАТ-ыг 10 хувиас доогуур ногдуулах нь ховор байдаг. НӨАТ-ын хувь хэмжээ дунджаар Европын Холбооны улсуудад 19.5 хувь, ЭЗХАХБ-ын гишүүн орнуудад 17.7 хувь, Латин Америкийн улс орнуудад 14.2 хувь, мөн Азийн орнуудын хувьд дунджаар 10.8 хувь байх бөгөөд Сингапур 7 хувь, Япон 5 хувь зэрэг цөөн орон доогуур хувь хэмжээтэй байдаг.

Харин худалдааны албан татварыг хэрэглэдэг улс орнуудын хувьд 3-8.25 хувь хэмжээ хэлбэлздэг.

- **Худалдааны татвар**

Худалдааны татвар нь 1918 онд зохиогдсон НӨАТ-ыг бодвол хамаагүй эртний буюу МЭӨ 2000 жилийн өмнө үүссэн гэж эрдэмтэд баталсан байна. Өнөө цагт Худалдааны татварыг орон нутгийн, эсхүл бүсийн хэмжээнд хэрэгжүүлдэг татвар болоод байна. Ингэхдээ уг татварын хувь хэмжээг орон нутгийн, эсхүл бүс нутгийг удирдах байгууллагаас тогтоох болсон бөгөөд бүр үүнээс болж Энэтхэгийн муж улсуудын хооронд татварын “хувь хэмжээний дайн” болж байжээ.[99]

Худалдааны татвар буюу (**sales tax**) нь НӨАТ-ын тогтолцоотой ойролцоо бөгөөд зөвхөн татвар ногдуулах үйлдвэрлэл үйлчилгээний түвшингөөр ялгагддаг. Үйлдвэрлэлийн худалдааны татвар, бөөний худалдааны татвар, импортын худалдааны татвар гэх зэрэг олон хувилбартай.

Эдгээр хувилбаруудаас түгээмэл ашиглагддаг нь жижиглэнгийн худалдааны татвар буюу (**retail sales tax**) юм. Энэ татварыг зөвхөн эцсийн хэрэглээнд ногдуулдаг бөгөөд бизнесийн хэрэглээнд ногдуулдаггүй. Бараа, ажил үйлчилгээ борлуулагч нь худалдан авагчаа эцсийн хэрэглэгч болон бизнесийн зорилгоор худалдан авч байгаа үйлчлүүлэгч гэж ялгавартай хандах шаардлагатай байдаг. Буцаан олголт хийдэггүй давуу талтай гэж тооцогддог боловч татвараас зугтах боломж илүү өндөр байдаг. Канадын Онтарио, Манитоба муж, АНУ-ын Аризона, Индиана мужуудад ногдуулж байна.

Манай улсын хувьд 1998 оноос өмнө худалдааны татвартай байсан бөгөөд 1998 оны 01 сарын 06-нд НӨАТ-ын тухай хууль батлагдаж, мөн оны 07 сарын 01-ний өдрөөс хууль хүчин төгөлдөр мөрдөгдсөн.

АНУ бол үндэсний худалдааны татваргүй цорын ганц хөгжингүй улс. Германы үндэсний худалдааны татвар 19 хувь, Их Британи 20 хувь, Өмнөд Солонгос 10 хувьтай байна.

ОХУ-д Худалдааны татварыг 2 ч удаа нэвтрүүлж байжээ: 1991 онд ЗХУ-ын хуулиар хэрэгжиж эхэлсэн бол 1998 онд шинээр ОХУ-ын орон нутгийн татвар хэлбэрээр ногдуулж байсан. Одоогийн үйлчилж байгаа НӨАТ нь 2004 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхлэн Татварын тухай хуулийн 28 бүлэг хүчин төгөлдөр болсон байна.

АНУ-ын муж улсуудын түвшинд Худалдааны татварыг хэрэгжүүлж байгаа. Цахим худалдаа гарч ирсэнтэй холбогдуулан худалдагч, худалдан авагч тус бүр өөр өөр муж улсад байхад барааны агуулах нь гурав дахь мужид байх гэх мэт асуудлаас болж уг татварын удирдлагыг хялбаршуулж болох юм.

[99]НДС или налог с продаж. Зарубежный опыт. Евгений Воловик эксперт, Финансовая газета. 21.06.2012. http://fingazeta.ru/discuss/49959/

- **НӨАТ болон Худалдааны татварын ялгаатай ойлголт[100]:**

НӨАТ-ын давуу болон сул тал:

- Уг татварын тогтолцоог сайн зохион байгуулж чадсан тохиолдолд татварын давхардлаас зайлсхийх боломжтой.
- НӨАТ нь бараа бүтээгдэхүүний үе шат бүр дээр төлөгдсөн НӨАТ-ыг бүрэн тооцдог.
- Өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа НӨАТ-ын хуулиар экспортын бүтээгдэхүүний “0” хувьтай байгаа бүтээгдэхүүний хувьд экспортлогчид орц худалдан авахдаа бүх НӨАТ-аа буцаан авч, манай улсаас экспортоор гарч байгаа бүтээгдэхүүний хувьд ямар ч НӨАТ шингээгүй байдаг.
- Татварын ачаллын тэгш хуваарилалт
- Татвар төлөхөөс зайлсхийх боломжгүй, хүндрэлтэй
- Бараа худалдан авагчийн статусыг шалгах шаардлагагүй /эцсийн худалдан авагч мөн эсэхийг/
- Зуучлагч /дамын наймаачид/ татвар төлнө.

НӨАТ тогтоосон орнуудын ерөнхий чиг хандлагаас харвал энэ төрлийн татварыг татварын тогтолцоонд нэг голлох татвар болон хувирсан. Үндсэн шалтгаан нь нэмэгдсэн өртгийн албан татвар нь[101]:

- Төсвийн орлогын найдвартай эх үүсвэр болдог;
- Татвар хураахад хялбар учир татварын тогтолцоог гажуудуулах нь бага;
- Татварын хяналт шалгалт хийх нөхцөлийг бүрдүүлдэг;
- Олон Улсын нийтлэг, стандарт загвартай тул олон улсын жишигт нийцсэн татварын тогтолцоог бүрдүүлэхэд хялбар зэрэг давуу талуудыг олгодог.

Дутагдалтай талыг нь:

- Татварын шударга байх, төлөгдөхүйц байх зарчмуудтай зөрчилдөх /хэрэглээгээр дамжин ногдуулдаг учир татвар төлөгчийн төлбөрийн чадвартай уялдаж чаддаггүйгээс нийгмийн орлого багатай, ядуу хэсэгт татварын дарамтыг үүсгэн, шударга бус тогтолцоо бүрдэнэ./
- Орлого хуваарилалтаар сөрөг нөлөөтэй /бага орлоготой өрхийн хувьд НӨАТ нь хэрэглээгээр дамжин төлдөг учир зайлшгүй бодит хэрэглээгээ бууруулахаас өөр аргагүй болдог нь тэдний амьжиргааны түвшинд сөргөөр нөлөөлдөг./

Худалдааны татварын давуу болон сул тал:

- Худалдааны татварын үед нийлүүлэлтийн сүлжээний эхний шатанд төлсөн татвар хоёр дахь шатны нийлүүлэгчийн борлуулалтын үнэнд шингэсэн байдаг учраас татварыг давхардуулан оногдуулдаг.
- Бараа үйлчилгээний жижиглэнгийн үнэнд шингэсэн худалдааны татварын хэмжээ нийлүүлэлтийн сүлжээнд байгаа үе шатны тооноос хамаарна. Ингэснээр компаниуд үйлдвэрлэлдээ ашигладаг ихэнх орцыг “өөрсдөө нийлүүлэх” сонирхолтой болж, энэ нь гол төлөв жижиг, дунд хэмжээний нийлүүлэгчдэд хохиролтой байдаг.
- Худалдааны татвар нь компаниудыг үйлдвэрлэлийн орц, түүхий эдийг импортоор авах замаар дотоодын худалдан авагч татвар төлөхөөс зайлсхийх хандлагыг бий болгодог. Ийнхүү импортын бүтээгдэхүүний сонгосноор дотоодын үйлдвэрлэгч компаниудын эдийн засгийг доройтуулах хандлагыг бий болгодог.
- Худалдааны татварын хувьд экспортлогчид хөнгөлөлт чөлөөлөлт үзүүлсэн ч экспортлогчдын орцонд шингэсэн худалдааны татварыг буцаан олж авах

[100]НДС или налог с продаж. Зарубежный опыт. Евгений Воловик эксперт, Финансовая газета. http://fingazeta.ru/discuss/49959/

[101]ТЕГ, МУИС-ХЗС, ШУА Монгол Улсын албан татварын эрх зүй, УБ-2009.

боломжгүй байдаг. Энэ татварын дарамт нь НӨАТ-тай улсуудын экспортлогчидтай харьцуулахад харьцангуй татварын дарамтыг бий болгож, экспортлогч компаниудын эдийн засгийн чадавхыг сул болгодог байна.
- Худалдааны татварын хувьд удирдлага, зохион байгуулалтын хувьд НӨАТ-аас энгийн зохион байгуулалттай байдаг давуу талтай боловч татварын ачааллын тэгш бус хуваарилалттай байна.
- Татвар төлөхөөс зайлсхийх боломжтой
- Бараа худалдан авагчийн статусыг шалгах шаардлагатай /эцсийн худалдан авагч мөн эсэхийг/
- Зуучлагч /дамын наймаачид/-д татвар ногдуулах боломжгүй.

Дээр дурдсан давуу болон сул талуудыг дэлгэрүүлэн авч үзье. Ямар ч татварын гол үзүүлэлтүүдийн нэг бол татвар төлөхөөс зайлсхийх боломж байгаа эсэх юм. НӨАТ болон Худалдааны татварыг харьцуулбал, Худалдааны татварын системийн хувьд худалдагчийн зүгээс түүний барааг худалдан авч байгаа этгээд эцсийн худалдан авагч мөн эсэх талаар асуулт байнга гарч ирнэ[102]: (1) хэрэв "тийм" бол худалдагч нь худалдан авагчаас татвар авна, (2) хэрэв "үгүй" бол бараагаа татваргүй худалдана. Гэхдээ худалдан авагч нь авч байгаа бараагаа худалдах зорилготой өөр нэг бүтээгдэхүүний үйлдвэрлэлд ашиглана гэж мэдүүлэх боломжтой, гэтэл хэрэг дээрээ бүтээгдэхүүн үйлдвэрлэж худалдахгүй. Энэ тохиолдолд худалдан авагч худалдааны татвараас зайлсхийж байгаа хэрэг. Мэдээж худалдан авалт бүрд Худалдааны татварыг ногдуулж болох боловч энэ тохиолдолд татварын ихээхэн хэмжээний ачаалал бий болно.

Энэхүү хоёр татварын давуу тал нь хадгаламж болон хөрөнгө оруулалтад хамаарахгүй явдал юм. Орчин үед улс орнууд, тэр байтугай хөгжилтэй гэж тооцогддог орнуудад шууд татвараас татгалзах хандлагатай болж, шууд бус татвар, тэр дундаа НӨАТ-ыг сонгох болсон байна. Дэлхий нийтийг хамарсан эдийн засгийн хямралаар Европын ихэнх улсуудад НӨАТ-ын татварын хувь хэмжээгээ нэмэгдүүлсний нэг нь Унгар улс хамгийн өндөр буюу 27 хувь болгож тогтоосон байна.

Хоёр. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ НӨАТ БОЛОН ХУДАЛДААНЫ ТАТВАРЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

- **Австрали** /НӨАТ-*Бараа ажил үйлчилгээний татвар*/

Уул уурхайн салбар өндөр хөгжсөн, ашигт малтмалын арвин их нөөцтэй энэ улс НӨАТ-ыг бараа ажил үйлчилгээний татвар (goods and service tax) гэсэн нэртэйгээр 2000 оны 07 сарын 01-ний өдрөөс эхлэн нэвтрүүлсэн бөгөөд энэ татвар нь ирээдүйд тус улсын төсвийн орлогын 4 гол эх үүсвэрийн нэг байх болно[103]гэж хүлээн зөвшөөрөгдсөн байна.

Бусад хөгжингүй орнуудтай харьцуулахад нэлээд сүүлд НӨАТ нэвтрүүлсэн орны хувьд хуулийн бүтэц, зохицуулалтууд нь харьцангуй боловсронгуй, орчин үеийн шинжтэй гэж тооцогддог байна.

Татварын хувь хэмжээ нь 10 хувь бөгөөд экспорт болон олон улсын тээврийн үйлчилгээнд тэг хувиар татвар ногдуулдаг, эрүүл мэнд боловсролын үйлчилгээ, хандив тусламж, буяны үйл ажиллагаа, газартай холбоотой гүйлгээ, зарим хүнсний бүтээгдэхүүнийг энэ татвараас чөлөөлдөг байна. Аж ахуйн нэгжийн хувь 75000 австрали доллар, ашгийн бус байгууллагын хувьд 150000 австрали доллараас дээш борлуулалттай бол татвар төлөгчөөр бүртгүүлэх үүрэг үүснэ.

[102]НДС или налог с продаж. Зарубежный опыт. Евгений Воловик эксперт, Финансовая газета. http://fingazeta.ru/discuss/49959/
[103]Dr Ken Henry report 2009, Australia's future tax system،

Австралийн НӨАТ-ын тогтолцоонд татвар төлөгч нь НӨАТ төлөгчөөр бүртгүүлэхдээ хэд хэдэн сонголт хийх боломжтой байдаг. Тухайлбал НӨАТ ногдуулах зарчимаа тодорхойлохын тулд Нягтлан бодох бүртгэлийн аккруэл болон мөнгөн суурийн аль нэгийг сонгох боломжтой аж. 2 сая австрали доллараас доош борлуулалттай бол мөнгөн суурийг сонгодог байна.

Энэ нь жижиг бизнес эрхлэгчдэд учрах татварын дарамт, мөнгөн урсгалын хомсдолыг бууруулах ач холбогдолтой байна. Мөн тайлан гаргах хугацааг сар, улирал, жилээр гэж сонгох боломжтой бөгөөд зөвхөн 20 саяас дээш борлуулалттай бол сараар тайлан гаргадаг аж.

Австралийн НӨАТ-ын тогтолцоонд уул уурхайн салбарт зориулсан тусгайлсан зохицуулалт байхгүй бөгөөд бусад татвар төлөгчдийн нэгэн адилаар зохицуулагджээ.

- **Индонези** /НӨАТ/

Индонези улс нь уул уурхайн салбараас дотоодын нийт бүтээгдэхүүний багагүй хэсгийг бүрдүүлдэг ашигт малтмал, газрын тос, байгалийн хийгээр баялаг орны нэг бөгөөд ази тивийн хөгжиж буй орны тоонд ордог тул тул энэхүү зөвлөмжид жишээ болгон авлаа.

Индонезийн НӨАТ-ын тухай хуулийг[104] баталснаар тус улс нь 1985 оны 4-р сарын 1-ний өдрөөс эхлэн өмнө нь үйлчилж байсан худалдааны татварыг халж НӨАТ нэвтрүүлжээ. Тус улсын хувьд үйл ажиллагааны чиглэлээс хамаарч 180-360 сая индонези рупи буюу 26-52 сая төгрөгтэй тэнцэх хэмжээтэй борлуулалт хийсэн тохиолдолд НӨАТ төлөгчөөр бүртгүүлдэг байна.

Тус улсын хуулиар нийтийн мэдээллийн хэрэгсэл, зочид буудал болон ресторан бусад хоолны газрын хоол хүнс, тус улсад олборлосон уул уурхайн бүтээгдэхүүн, өрөмдлөгийн ажил НӨАТ-аас чөлөөлөгддөг байна. Мөн эрүүл мэнд боловсрол, банк, санхүү, даатгалын үйлчилгээ, шуудан, нийтийн тээврийн үйлчилгээ татвараас чөлөөлөгддөг байна.

НӨАТ нь манай улстай адил 10 хувь бөгөөд тайланг сараар гаргадаг байна. Татварын тайлангаа цаг хугацаандаа өгдөг, татварын ямар нэгэн өргүй зэрэг тодорхой шалгуур үзүүлэлтийг хангасан байгууллагыг “алтан” статустай татвар төлөгчид оруулна.

“Алтан” статустай татвар төлөгчийг жил бүр Татварын ерөнхий захирал /DGT–Director General of Tax/ тогтооно. “Алтан” статустай татвар төлөгч нь урьдчилан аудитын шалгалтад орж, НӨАТ-ын буцаан олголт эрт авах боломжтой. Хэрэв “алтан” статустай татвар төлөгч нь татварын буцаан олголтоо хэтрүүлж авсан нь аудитын шалгалтаар тогтоогдвол захиргааны торгуулийг 100 хувь төлнө.

- **Казахстан** /НӨАТ/

Казахстан Улс нь газарзүйн байрлал болон эдийн засгийн бүтцийн хувьд Монгол Улстай төстэй бөгөөд ашигт малтмал, газрын тосны асар их баялагтай орон тул жишээ болгон оруулав.

Казахстан Улс 2009 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхлэн НӨАТ-ын шинэчилсэн найруулгыг хэрэгжүүлж эхэлсэн[105] бөгөөд татвар ногдуулах зүйл, чөлөөлөлт буцаан олголттой холбоотой хэд хэдэн чухал өөрчлөлтүүдийг шинэчлэн мөрдөж эхэлжээ.

[104]Indonesia VAT Law.
[105]Налоговый кодекс РК.

Татварын хувь хэмжээ нь 12 хувь бөгөөд, тайланг улирлаар гаргадаг байна. Мөн тайлан гаргаснаас хойш 10 хоногт багтаан татвараа төлөх үүрэг хүлээдэг байна.

НӨАТ төлөгчөөр бүртгүүлэх босго нь 42390000 тенге буюу 286500 ам.доллар, ойролцоогоор 360 сая монгол төгрөгтэй тэнцэнэ. Зарим төрлийн эм, эмчилгээний эм бэлдмэл, түүхий эд, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг импортын НӨАТ-аас чөлөөлдөг байна. Онцлог нь Төв банкинд худалдсан үнэт металд тэг хувиар НӨАТ ногдуулдаг байна.

- **Канад** /НӨАТ-Бараа үйлчилгээний татвар/

1991 оны 01 сарын 01-ний өдрөөс Холбооны улсын болон муж улсын худалдааны татварыг уялдуулсан өвөрмөц татварыг бий болгожээ. Энэ татварыг нэвтрүүлснээр үйлдвэрлэгчдийн худалдааны татвар болон харилцаа холбооны татварыг хүчингүй болгожээ.

Тус улсын холбооны улсын бараа үйлчилгээний татвар (goods and service tax) буюу НӨАТ-ын хувь хэмжээ нь 5 хувь байдаг. 30000 канад доллараас дээш борлуулалттай аж ахуйн нэгж, 50000 канад доллараас дээш борлуулалттай ашгийн бус байгууллага татвар төлөгчөөр бүртгэгдэнэ.

Энэ улсын гол онцлог нь муж улсууд нь өөрийн худалдааны татвартай ба 2 төрлийн шууд бус татварыг давхар ногдуулдаг. Гэвч сүүлийн үед муж улсууд эдгээр 2 татварын нэгтгэж эхэлсэн байна. Одоогоор Алберта, Юкон, Нанюват, Баруун хойд муж зөвхөн холбооны 5 хувийн НӨАТ-тэй байгаа ба нийлмэл татварыг Британш Колумбиа 12, Манитоба 12, Нью Бруинсвик 13, Лабрадор 13, Ньюскотиа 15, Онтарио 13 хувиар тус тус ногдуулж байна. Түүнчлэн 2 татварыг ногдуулах дараалал нь муж бүрд өөр байдгаас нийлмэл хувь хэмжээ нь мөн өөрчлөгддөг аж.

Онцлог тал нь экспортын бараа үйлчилгээнээс гадна зарим хүнсний бүтээгдэхүүн, жороор олгогдох эм, дотоодын болон олон улсын нийтийн тээврийн үйлчилгээ, эмнэлгийн тоног төхөөрөмжид тэг хувиар татвар ногдуулдаг байна. Эрүүл мэнд боловсрол, банк санхүүгийн үйлчилгээнээс гадна хуулийн зөвлөгөө өгөх үйлчилгээ НӨАТ-аас чөлөөлөгддөг байна.

- **Нидерланд** /НӨАТ/

Нидерланд Улс нь 1968 онд батлагдсан НӨАТ-ын тухай хуулиар[106] зохицуулагдана. НӨАТ-ын стандарт хувь хэмжээ 19 хувь байна. 6 хувийн бууруулсан хувь хэмжээ нь импорт болон Хамтын нийгэмлэгийн дотор бараа, үйлчилгээ авах үйл ажиллагаа болно.

Бууруулсан хувь хэмжээнд хоол хүнсний бүтээгдэхүүн болон эмчилгээний эмийн бүтээгдэхүүн хамаарна.

Мөн түүнчлэн ус, урлаг, ном, сонин, сэтгүүл, харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан туслах багаж, хиймэл эрхтэн, газар тариалангийн зарим бараа, үйлчилгээ, зорчих тээвэр, спорт, хөдөлмөр шаардсан үйлчилгээ болон театр, жүжиг, музей, кино театр, спортын арга хэмжээ, хөгжөөнт тоглоомын парк, амьтны хүрээлэн, циркийн орох тасалбар зэрэг бараа үйлчилгээнд ногдуулах татварын хэмжээ харьцангуй бага байна.

[106]ftnref1 Wet op de omzetbelasting 1968 – Wet OB.
Эх сурвалж: http://wetten.overheid.nl/BWBR0002629/geldigheidsdatum_04-07-2013

- **ОХУ** /НӨАТ/

Нэг талаас хөрш орон, нөгөө талаас худалдаа эдийн засгийн томоохон түншийн хувьд ОХУ-ын НӨАТ-ын тогтолцоог авч үзлээ. 2001 оны 01 сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөгдсөн НӨАТ нь ОХУ-ын төсвийн орлогын 30-35 хувийг бүрдүүлдэг төсвийн орлогын хамгийн том эх үүсвэр юм.

ОХУ-ын НӨАТ-ын хуулийн үг хэллэгийг маш нарийн чанд, дэлгэрэнгүй тайлбарласан байдаг. Тухайлбал, эрүүл мэндийн үйлчилгээг чөлөөлөлтөд хамааруулахдаа энэ чөлөөлөлтөд эмнэлгийн тоног төхөөрөмж, хиймэл эрхтэн, түүний түүхий эд сэлбэг, тахир дутуу хүний тэрэг тэргэнцэр, харааны шил, линз (нарны шилнээс бусад), гоо сайхны мэс заслаас бусад хувийн болон эмнэлэгийн эмчилгээ, оношилгооны үйлчилгээ, эрүүл мэндийн даатгалын үйлчилгээ, цус хүлээн авах, сэлбэх үйлчилгээ, эмнэлгийн яаралтай тусламж, задлан шинжилгээ, жирэмсэн эхчүүд болон нярай хүүхдийн асаргаа, наркологийн эмчилгээ, өндөр настны болон тахир дутуу хүмүүсийн асрамжийн газрын үйлчилгээ хамаарна гэж нарийн зааж өгсөн байна.

Тус улсад ерөнхий хувь хэмжээ нь 2004 оноос эхлэн 18 хувь бөгөөд зарим хүнсний бараа, эм, хүүхдийн хувцас, ном, сонин сэтгүүлийн борлуулалтад 10 хувиар ногдуулдаг байна. Татвар төлөгчөөр бүртгүүлэх босго нь 2 сая рубль буюу ойролцоогоор 90 сая төгрөг байна.
Татварын тайлан гаргах хугацаа нь улирлаар тооцогдох ба татвараа улирлын дараа сарын 20-ний дотор тайлагнаж төлнө.

Хамгийн сонирхолтой хэсэг нь НӨАТ-ын буцаан олголтой холбоотой хэсэг юм. НӨАТ-ын буцаан олголт нь ОХУ-ын татварын тогтолцооны хамгийн эмзэг хэсэг гэж тооцогддог бөгөөд түүнийг буцаан олгохын тулд маш олон тооны баримт материал шаардаж, олон төрлийн шаардлага тавьдаг байна. Тухайлбал экспортод гаргасан барааны НӨАТ-ын буцаан олголтыг баталгаажуулж буцаан олгохын тулд тэдэнд экспортын орлого нь бараа хилээр гарснаас хойш 6 сарын дотор ОХУ-ын банкинд дахь дансанд орсон байх, бараа солилцоогоор төлбөрийг авахаар тохиролцсон бол уг бараа нь ОХУ-ын нутаг дэвсгэрт орж ирсэн нь гаалийн байгууллагаар нотлогдсон байх, бэлэн мөнгө хүлээн авсан бол уг мөнгөө ОХУ-ын арилжааны банкинд дахь дансанд төвлөрүүлсэн нь банкны тодорхойлолтоор нотлогдсон байх гэх мэт шаардлага тавьдаг байна.

Мөн барааг экспортод гаргасан гаалийн мэдүүлэг, барааг хилээр нэвтрүүлсэн гэсэн тэмдэглэгээ бүхий тээврийн бичиг баримт, экспортын орлого дансанд төвлөрсөн тухай арилжааны банкны тодорхойлолт, санхүүгийн тайланд тусгасан тэмдэглэл, татвар төлөгчийн хүсэлт, экспортын гэрээний 1 хувь гэх мэт материалыг хавсаргахыг шаарддаг байна. Хэрэв илүү төлөлтийг баталгаажуулах явцад аливаа зөрчил илэрвэл буцаан олголт олгохоос татгалзах үндэслэл болдог байна.

ОХУ-ын Төв банк, эрдэнэсийн санд худалдсан алмаз болон үнэт металл, мөн цаашид боловсруулахаар худалдсан үнэт металлын агуулга бүхий хүдэр, баяжмалын борлуулалт, Төв банк болон Эрдэнэсийн сангаас борлуулсан үнэт металл болон алмазын борлуулалт НӨАТ-аас чөлөөлөгддөг байна.

- **БНХАУ** /НӨАТ/

Манай орны худалдаа, эдийн засгийн гол түнш, томоохон хөрөнгө оруулагч бөгөөд хөрш орны хувьд тус орны НӨАТ-ын тогтолцоог жишээ болгон авав.

Хятад Улс НӨАТ-ыг 1984 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхлэн зөвхөн 24 төрлийн бизнесийн үйл ажиллагаанд нэвтрүүлж эхэлсэн бол 1994 оноос эхлэн өнөөгийн мөрдөж байгаа хууль

хэрэгжиж эхэлжээ. БНХАУ-ын НӨАТ-ын тогтолцоо нь дэлхийд хамгийн нүсэр бөгөөд хамгийн хүчтэй “орлого цуглуулагчид” тооцогддог ба улсын төсвийн орлогын 40-47 хувийг цуглуулдаг байна.

НӨАТ-ын хувь хэмжээний хувьд татвар төлөгчдийг 2 ангилдаг бөгөөд 500000 юаньас доош борлуулалттай үйлдвэрлэл эрхлэгчид, 800000 юаньас доош борлуулалттай худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийг жижиг татвар төлөгчид гэж тооцно.

Жирийн НӨАТ төлөгчид нь Монгол Улсад хэрэгждэг падаany аргаар буюу борлуулалтын НӨАТ болон худалдан авалтын НӨАТ-ын зөрүүгээр төлөх татвараа тодорхойлдог бол жижиг татвар төлөгчид нийт борлуулалтын орлогын 3 хувиар НӨАТ төлдөг байна.

Экспортын бүтээгдэхүүнд 0 хувиар, өргөн хэрэглээний хүнсний ногоо, үр тариа, хөдөө аж ахуй, ой, далайн болон мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн, ном, сонин сэтгүүл, усан хангамж, халаалт, шатдаг хий, шингэрүүлсэн түлш, ахуйн хэрэглээний нүүрс, нэр бүхий металл болон металл бус эрдсийн түүхий эд, нүүрс, бордоо, хөдөө аж ахуйн химийн бүтээгдэхүүн, ХАА-н машин техник зэрэг нэр бүхий зарим бараа ажил үйлчилгээнд 13 гэсэн хувь хэмжээгээр, бусад бараа, үйлчилгээнд 17 хувиар НӨАТ ногдуулна.

Боловсрол шинжлэх ухаан, судалгаа шинжилгээний зориулалтаар импортолсон тоног төхөөрөмж, хөдөө ахуйн анхдагч бүтээгдэхүүн үйлдвэрлэгч хувь хүн, хоршоолол, нөхөрлөлийн өөрсдийн тарьж ургуулсан болон үржүүлсэн бүтээгдэхүүн, буцалтгүй тусламжийн бараа, тахир дутуу хүнд зориулсан тоног төхөөрөмж, тахир дутуу хүмүүсийн үзүүлсэн үйлчилгээ НӨАТ-аас чөлөөлөгдөнө.

Үүний зэрэгцээ барилга, нийтийн тээвэр, банк, санхүү, даатгалын үйлчилгээ, аялал жуулчлал, шуудан, харилцаа холбоо, соёл, урлаг, спорт, уран сайхны үйлчилгээ, тоглоом, амралт зугаалгатай холбоотой үйлчилгээнд НӨАТ ногдуулдаггүй бөгөөд эдгээр үйлчилгээнд Бизнесийн татвар гэдэг тусгай татвар ногдуулдаг байна.

Бас нэг онцлог нь үндсэн хөрөнгө болох байшин барилга, тоног төхөөрөмж худалдан авах үед төлсөн НӨАТ-ыг хасаж тооцдоггүй байна. Энэ нь НӨАТ-ын илүү төлөлт, буцаан олголт нэмэгдэхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх боловч нөгөө талдаа хөрөнгө оруулалтын өртөг, элэгдлийн зардлыг нэмэгдүүлэх, улмаар орлогын албан татварын хэмжээг бууруулах нөлөөтэй байна.

НӨАТ-ын падаany ашиглалтыг хянахад хүндрэлтэй байдгаас зарим тохиолдолд НӨАТ-ын падаanыг татвар төлөгчийн өмнөөс татварын алба холбогдох баримтыг үндэслэн олгох журам ч зарим мужуудад үйлчилж байна. Импортын үйлчилгээнд НӨАТ болон Бизнесийн татварын хувьд урвуу ногдуулалд буюу reverse charge rule-ийг мөрдөж байна.

- **Чили** /НӨАТ/

Чилийн Татварын албаны дарга Julio Periera-ийн 2011 оны 3-р сарын 23-ны өдөр тавьсан Татварын орлогын тухай илтгэлд[107] дурдсанаар зэс, молибденийн үйлдвэрлэлээр дэлхийд тэргүүлэгч Чили улсын 2010 оны нийт төсвийн татварын орлого 17,7 триллион песо байснаас НӨАТ-ын орлого түүний 47,7 хувь буюу 8,3 триллион песо байгааг дурджээ. Үүний зэрэгцээ 2011 онд Чилийн татварын албаны гол зорилт нь “НӨАТ-ын ногдуулалтад тавих хяналт шалгалтын үр дүнг дээшлүүлэх явдал” гэж онцолжээ.

[107]The SII Commissioner Julio Pereira, 2011, 2010 Official Accounts address, Santiago،

Тэр бээр хэлэхдээ дэлхийн зах зээл дэх зэсийн үнэ тааламжтай өндөр түвшинд байгаа нь улс орны эдийн засагт нэн тааламжтай нөхцөлийг бүрдүүлж байгаа хэдий ч НӨАТ нь цаашид төсвийн орлого бүрдүүлэх хамгийн гол хэрэгсэл байх болно гэжээ. Үүнээс үзэхэд Чили улс төсвийн орлогоо бүрдүүлэхдээ НӨАТ-ын үүрэг, ач холбогдлыг тэргүүн ээлжид тавьж байна.

Чили Улсын НӨАТ нь падааны аргад суурилсан бөгөөд бараа ажил үйлчилгээний үнийн дүнгийн 19 хувиар ногдуулдаг байна. Сар бүр тайлан гаргадаг.

- **АНУ** /Худалдааны татвар/

Эдийн засгийн цар хүрээ, хөгжлийн түвшингөөр дэлхийд тэргүүлэгч АНУ-ын хувьд өнөөг хүртэл холбооны улсын түвшинд НӨАТ нэвтрүүлээгүй байгаа бөгөөд ялангуяа НӨАТ-ын тогтолцоог эсэргүүцэгчид энэ орныг жишээ болгон авч эсэргүүцлээ дэвшүүлэн тавьдаг тул учир шалтгааныг нь судлах, дүгнэлт гаргах зайлшгүй шаардлагатай. Иймд энэ улсад яагаад өнөөг хүртэл холбооны хэмжээнд НӨАТ-ыг нэвтрүүлэхгүй байгааг бусад эрдэмтэн судлаачдын судалгаанаас авч үзвэл:

АНУ-ын 50 муж улсын 45 нь шууд бус татварын аливаа нэг хэлбэрийг төсвийн орлогоо бүрдүүлэхэд ашигладаг бөгөөд жижиглэнгийн худалдааны татвар голлох байр суурь эзэлж байна.

АНУ-д холбооны хэмжээнд НӨАТ нэвтрүүлэх санаачилга анх 1862 онд иргэний дайны үед дараа нь 1942 онд Дэлхийн II дайны үед хүчтэй тавигдаж байжээ. Улмаар 1969 онд ерөнхийлөгч Р.Никсон, 1977 оны эхээр ерөнхийлөгч Форд, түүний дараа ерөнхийлөгч Ж.Картер, 1984 онд ерөнхийлөгч Р.Рейган, 2005 онд ерөнхийлөгч Ж.Бушийн Засгийн газрууд татварын тогтолцоог шинэчлэх ажлын хүрээнд орлогын албан татварын үүргийг бууруулж НӨАТ нэвтрүүлэх, төсвийн алдагдлыг бууруулах санаачилгуудыг гаргаж байжээ. Гэвч тухай бүр дэмжлэг олоогүй байна. Уэйнийн их сургуулийн профессор Алан Шенкийн тайлбарласнаар[108] өнөөгийн Б.Обамагийн Засгийн газар төсвийн алдагдлыг бууруулах, эрүүл мэндийн даатгалын тогтолцоог санхүүжүүлэх эх үүсвэр хайх арга замыг судалж байгаа бөгөөд энэ 2 асуудлыг зэрэг шийдвэрлэх цорын ганц арга нь НӨАТ гэжээ.

НӨАТ нэвтрүүлэх асуудал нь тухай улс орны эдийн засагт олон эерэг дүн авчрах ач холбогдолтой ч улс төрийн шийдлийн хувьд “амиа хорлолт” болдог ажээ. Тухайлбал 1986 онд Япон Улсад НӨАТ нэвтрүүлсэн ерөнхий сайд Я.Накасонэ, 1991 онд Канад Улсад НӨАТ нэвтрүүлсэн ерөнхий сайд Б.Малруни нар сонгуульд ялагдаж байсан ба Австрали Улсад НӨАТ нэвтрүүлсэн ерөнхий Ж.Ховардын нам парламентад олон суудлаа алдаж байжээ.

АНУ-ын Дотоод орлогын газарт ирүүлсэн нийт орлогын тайлангийн талаас доош буюу 45-48 хувь нь татвар төлөхөөргүй, хөнгөлөлт чөлөөлөлтөд хамрагдсан тайлан байдаг бөгөөд хэрэв НӨАТ нэвтрүүлбэл хүн бүр татвар төлдөг илүү шударга зарчимд шилжинэ гэж үздэг. Гэвч амархан аргаар хэт их төсвийн орлого цуглуулах нь төрийн алба, засгийн газрыг томорход хүргэж эдийн засгийн бүтцэд сөрөг нөлөөлөл үзүүлнэ гэдэг үзэл өнөөг хүртэл давамгайлсан хэвээр байна.

Судлаачдын үзэж байгаагаар[109], АНУ-д НӨАТ нэвтрүүлэхээс татгалзахад хүргэдэг үндсэн шалтгаанууд нь улс төрийн шалтгаанаас гадна дараах бүлэгт хуваагдахаар байна. Үүнд:

[108]Alan Schenk, 2011, Prior US flirtations with VAT, VAT reader, Tax analysts,
[109]Douglas Holtz-Eakin, 2011. The case against VAT, VAT reader, Tax analysts.

1. НӨАТ нэвтрүүлэх нь төсвийн зардлыг бууруулах төсөв санхүүгийн бодлогын ерөнхий зарчимд нийцэхгүй. НӨАТ нэвтрүүлснээр төсвийн алдагдлыг бууруулах боломжтой боловч энэ нь улмаар төсвийн зарлагыг нэмэгдүүлэхэд хүргэж НӨАТ-ын хувь хэмжээг байн байн нэмэгдүүлэхэд хүргэнэ. Тухайлбал АНУ саяхан НӨАТ-ын хувь хэмжээгээ 2 хувиар нэмсэн нь дээрх учир шалтгаантай холбоотой.
2. НӨАТ-ын тухай хуулийг хэлэлцэх явцад түүний бүтэц дизайн, ялангуяа хувь хэмжээ, чөлөөлөлтийн хүрээ хэрхэн өөрчлөгдөхийг таамаглах аргагүй.
3. Муж улсууд дийлэнх нь шууд бус татварыг төсөв бүрдүүлэхдээ ашигладаг тул тэдгээрийг холбооны татвартай уялдуулах, эсхүл өөрчлөх нь зөвхөн улс төрийн хувьд бус хэрэгжүүлэх боломжийн хувьд төсөөлшгүй юм.
4. Бага орлоготой хүмүүс нь орлогынхоо дийлэнх хэсгийг хэрэглээнд зарцуулдгаас НӨАТ нь бага орлоготой хүмүүст илүү дарамттай байдаг. Энэ нь мөн дундаж орлоготой хүмүүст ч хамаарах тул орлого хуваарилалтын зарчимд нийцдэггүй байна.
5. Төсвийн алдагдал өндөр, эдийн засгийн байдал зөвхөн хямралаас гарах түвшинд байгаа өнөө үед татварын тогтолцоонд шинэчлэл хийх нь эдийн засгийг дахин хямрахад хүргэнэ гэж үзэж байна.

- **Энэтхэг** /НӨАТ, Худалдааны татвар/

Энэтхэг Улсад үндэсний худалдааны татварын зэрэгцээ НӨАТ-ын татварыг зарим нэр төрлийн бараанд ногдуулдаг байна. Үндэсний худалдааны татварын тухай хуулийг[110] 1956 онд баталж, 1957 оны 1-р сарын 5-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болсон. Энэхүү хууль нь муж улс хооронд бараа шилжүүлэх буюу бараа худалдахад ногдуулж байгаа татварын харилцааг зохицуулна. Муж улс хоорондын бараа шилжүүлэхэд нэг муж улсаас нөгөө муж улсад бараа шилжүүлэх, мөн бараа эзэмших эрхийн бичиг шилжүүлэхийг багтаана. Өөр муж улсад бараа худалдаж байгаа хүн бүр бүртгүүлж худалдааны татварыг төлөх ёстой.

Анхандаа Худалдааны татварын хувь хэмжээ 1 хувь байгаад 2-3 хувь болж өсөж байгаад 1975 онд 4 хувь хүртлээ өссөн байна. Харин 2008 оны 7-р сарын 1-ээс 3-2 хувь болж эргэж буусан бөгөөд бараа худалдан авч байгаа худалдан авагч, түүний оршин суугаа муж улсаас энэ хувь хамаарна. Хэрэв бараа худалдан авагч нь үйлдвэрлэгч, худалдагч, эсхүл Үндэсний худалдааны татварын тухай хуулиар тогтоосон журмын дагуу барааг ашиглах гэж байгаа бол хөнгөлөлттэй буюу 2 хувийн татвар ногдуулна.

Сүүлийн үеийн судалгаануудаас үзэхэд АНУ-аас гадна Багамын арлууд, Бахрейн, Британийн Виржиниа, Бермуда, Бруней, Хонгконг, Макао, Кейманы арлууд, Гибралтар, Гуэрнси, Ирак, Кувейт, Ливи, Малдив,Оман, Катар, Сан-Марино, Саудын Араб, Арабын Нэгдсэн Эмират улс зэрэг 17 улс, автономит мужууд НӨАТ-гүй байгаа бөгөөд тэдгээрээс Арабын орнуудад НӨАТ нэвтрүүлэх асуудал тавигдаж эхлээд байна. Түүнчлэн БНАСАУ (Хойд Солонгос) 15 хувиар, Куба 2-20 хувиар НӨАТ ногдуулдгийг ч дурдаж болно.

[110]Central Sales Tax Act /CST/, 1956. http://dor.gov.in/acts_rules.

Хүснэгт 1. Дэлхийн улс орнуудад мөрдөж буй татварын төрөл, хувь хэмжээ

№	Улсын нэр	Татварын төрөл	Мөрдөж эхэлсэн хугацаа	Татварын хувь хэмжээ	Нэмэгдүүсэн болон бууруулсан хувь хэмжээ
1	Albania	НӨАТ *Value-added tax (VAT)*	1995.04.27	10-20%	
2	Argentina	НӨАТ *Value-added tax (VAT)* Гүйлгээний татвар *Turnover tax*	-	10.5-21%	Нэмэгдүүлсэн 27%
3	Armenia	НӨАТ *Value-added tax (VAT)*	1993.07.01	20%	
4	Aruba	Орлогын татвар *Revenue tax (RT)*	2007.01.01	1.5%	
5	Australia	Бараа ажил үйлчилгээний татвар *Goods and services tax (GST)*	2000.07.01	10%	
6	Austria (EU[111])	НӨАТ *Value-added tax (VAT)*	1973.01.01	19-20%	Бууруулсан 10-12%
7	Azerbaijan	НӨАТ *Value-added tax (VAT)*	1992.01.01	18%	
8	Barbados	НӨАТ *Value-added tax (VAT)*	1997.01.01	17.5%	Бууруулсан 8.75%
9	Belarus	НӨАТ *Value-added tax (VAT)*	1991.12.19	20%	Бууруулсан 10%
10	Belgium (EU)	НӨАТ *Value-added tax (VAT)*	1971.01.01	21%	
11	Bolivia	НӨАТ *Value-added tax (VAT)*	1986.06	13-14.94%	
12	Bonaire, Sint Eustatius and Saba (BES-Islands)	Хэрэглээний татвар *General expenditure tax*	2011.01.01	6-8%	Зарим бараа бүтээгдэхүүнд 18%-30%
13	Botswana	НӨАТ *Value-added tax (VAT)*	2002.07.01	12%	
14	Brazil	Холбооны НӨАТ *State Value-Added Tax (ICMS)* Мужийн НӨАТ *Federal Value-Added Tax (IPI)* Орон нутгийн үйлчилгээний татвар *Municipal Service Tax (ISS)* Холбооны нийгмийн татвар[112]	1989 1964 1968 1990	1,5-35%	/ICMS/ Муж улс дотор 1.5-35% Муж улс хооронд таваарын эргэлт мужаас хамаарч 7-12% /IPI/ Таваарын ангилалаас хамаарч 0-330%, /ISS/ Орон нутгаас хамаарч PIS-PASEP 0,65%[113] COFINS 3%[114] ,6%[115]
15	Bulgaria (EU)	НӨАТ Value-added tax (VAT)	1994.01.01	9-20%	
16	Canada	Бараа ажил үйлчилгээний татвар *Goods and services tax (GST)* Нэгтгэсэн үйлчилгээний татвар[116] *Harmonized Services Tax (HST)*	1991.01.01	5-9.5%	

[111]EU-European Union member state
[112]Contribuiзго para os programas de integrazго social e de formazго do patrimфnio public (PIS-PASEP)-/үгчилж орчуулбал/ Нийгмийн нэгдсэн хөтөлбөр, болон нийгмийн фондуудад зориулсан нэмэр хандив
[113]/кумулятив системын дагуу орлогын татварыг төсөөлөн тооцоох аргад хамаарах татвар төлөгчид /1,65%/ кумулятив бус системын дагуу жилийн бодит орлогын татвар тооцоох аргад хамаарах татвар төлөгчид/
[114]/кумулятив системын дагуу орлогын татварыг төсөөлөн тооцоох аргад хамаарах татвар төлөгчид/
[115]/кумулятив бус системын дагуу жилийн бодит орлогын татвар тооцоох аргад хамаарах татвар төлөгчид/
[116]GST буюу бараа ажил үйлчилгээний татвар болон PST буюу орон нутгийн худалдааны татвариг нэгтгэн ногдуулдаг нэгтгэсэн үйлчилгээний татвар юм

17	Chile	НӨАТ *Value-added tax (VAT)*	1974.12.31	19%	
18	China	НӨАТ *Value-added tax (VAT)*	1994.01.01	13-17%	
19	Colombia	НӨАТ *Value-added tax (VAT)*	1983.12.29	5-16%	
20	Costa Rica	НӨАТ *Value-added tax (VAT)*	1982.11.08	13%	Бууруулсан 5-10%
21	Croatia	НӨАТ *Value-added tax (VAT)*	1998.01.01	25%	Бууруулсан 5-10%
22	Curaзao	Гүйлгээний татвар *Turnover tax (TOT*)	1999.03.01	6%	
23	Cyprus (EU)	НӨАТ *Value-added tax (VAT)*	1992.07.01	8%	Бууруулсан 5-8%
24	Czech Republic (EU)	НӨАТ *Value-added tax (VAT)*	1993.01.01	21%	Бууруулсан 15%
25	Denmark (EU)	НӨАТ *Value-added tax (VAT)*	1967.07.03	25%	
26	Dominican Republic	Үйлдвэржсэн бараа үйлчилгээний татвар *Tax on the Transfer of Industrialized Goods and Services*	1992.05	18%	Энэхүү татвараа 2014.12.31-нээс 16%
27	Ecuador	НӨАТ *Value-added tax (VAT)*	1991.12.31	12%	
28	Egypt	Үндэсний худалдааны татвар *General sales tax*	1991.05.03	10%	
29	El Salvador	НӨАТ *Value-added tax (VAT)*	1992.07	13%	
30	Estonia (EU)	НӨАТ *Value-added tax (VAT)*	1991.01.01	9-20%	
31	Finland (EU)	НӨАТ *Value-added tax (VAT)*	1994.06.01	24%	Бууруулсан 10-14%
32	France (EU)	НӨАТ *Value-added tax (VAT)*	1994.06.01	24%	Бууруулсан 10-14%
33	Georgia	НӨАТ *Value-added tax (VAT)*	1993.12.24	18%	
34	Germany (EU)	НӨАТ *Value-added tax (VAT)*	1968.01.01	7-19%	
35	Ghana	НӨАТ *Value-added tax (VAT)*	1998.03.18	12.5%	
36	Greece (EU)	НӨАТ *Value-added tax (VAT)*	1987.01.01	23%	Бууруулсан 6.5-13%
37	Guatemala	НӨАТ *Value-added tax (VAT)*	1992.07.01	12%	Бууруулсан 5%
38	Honduras	НӨАТ *Value-added tax (VAT)* Худалдааны татвар *Sales tax*	1964.01.01	12-15%	
39	Hungary (EU)	НӨАТ *Value-added tax (VAT)*	1988.01.01	27%	Бууруулсан 5-18%
40	Iceland	НӨАТ *Value-added tax (VAT)*	1990.01.01	25.5%	Бууруулсан 7%
41	India	НӨАТ *Value-added tax (VAT)* Үйлчилгээний татвар *Service tax* Үндэсний худалдааны татвар *Central sales tax (CST)*	2005.04.01 1994 1956	12.5-15% 12.36% 2%	

42	Indonesia	НӨАТ *Value-added tax (VAT)*	1984.01.01	10%	
43	Ireland, Republic of (EU)	НӨАТ *Value-added tax (VAT)*	1972.11.01	23%	Бууруулсан 4.8%, 9% 13%
44	Isle of Man	НӨАТ *Value-added tax (VAT)*	1973.04.01	20%	Бууруулсан 5%
45	Israel	НӨАТ *Value-added tax (VAT)*	1976.06.01	17%	
46	Italy (EU)	НӨАТ *Value-added tax (VAT)*	1973.01.01	21%	Бууруулсан 4%-10%
47	Japan	Хэрэглээний татвар *Consumption tax*	1989.04.01	5-8%	2014.04.01-ний өдрөөс уг татварыг 8%, 2015.10.01-нээс 10% болгоно.
48	Jersey, Channel Islands	Бараа ажил үйлчилгээний татвар *Goods and services tax (GST)*	2008.05.06	5 %	
49	Jordan	Үндэсний худалдааны татвар General sales tax Үндэсний татвар General Tax Онгой татвар Special Tax	1994.06	4-16%	
50	Kazakhstan	НӨАТ *Value-added tax (VAT)*	1991.12.24	12%	
51	Kenya	НӨАТ *Value-added tax (VAT)*	1990.01.01	12-16%	
52	Korea (South)	НӨАТ *Value-added tax (VAT)*	1977.01.01	10%	
53	Latvia (EU)	НӨАТ *Value-added tax (VAT)*	1995.05.01	12-21%	
54	Lebanon	НӨАТ *Value-added tax (VAT)*	2002.02.01	10%	
55	Lithuania (EU)	НӨАТ *Value-added tax (VAT)*	1994.05.01	21%	Бууруулсан 5-9%
56	Luxembourg (EU)	НӨАТ *Value-added tax (VAT)*	1969.08.05	15%	Бууруулсан 3-12%
57	Macedonia, Former Yugoslav Republic of	НӨАТ *Value-added tax (VAT)*	2000.04.01	5-18%	
58	Malaysia	Худалдааны болон үйлчилгээний татвар *Sales tax and service tax*	1972.02.29	5-10%	
59	Malta (EU)	НӨАТ *Value-added tax (VAT)*	1999.01.01	18%	Бууруулсан 5-7%
60	Mauritius	НӨАТ *Value-added tax (VAT)*	1998.09.07	15%	
61	Mexico	НӨАТ *Value-added tax (VAT)*	1980.01.01	16%	Бууруулсан 11%
62	Moldova	НӨАТ *Value-added tax (VAT)*	1998.07.01	20%	Бууруулсан 8%
63	Morocco	НӨАТ *Value-added tax (VAT)*	1986.01.01	20%	Бууруулсан 7-14%
64	Namibia	НӨАТ *Value-added tax (VAT)*	2000.11.27	15%	
65	Netherlands (EU)	НӨАТ *Value-added tax (VAT)*	1969.01.01	21%	Бууруулсан 6%
66	New Zealand	Бараа ажил үйлчилгээний татвар *Goods and services tax (GST)*	1986.10.01	15%	
67	Nicaragua	НӨАТ *Value-added tax (VAT)*	1984.12.21	15%	
68	Nigeria	НӨАТ *Value-added tax (VAT)*	1993.08.24	5%	

69	Norway	НӨАТ *Value-added tax (VAT)*	1970.01.01	25%	Бууруулсан 8-15%
70	Pakistan	Худалдааны татвар *Sales tax*			
71	Panama	НӨАТ Value-added tax (VAT)	1976.12.22	7%	Нэмэгдүүлсэн 10%-15%
72	Papua New Guinea	Бараа ажил үйлчилгээний татвар *Goods and services tax (GST)*	2004.01.01	10%	
73	Paraguay	НӨАТ *Value-added tax (VAT)*	1992.07.01	5%-10%	
74	Peru	НӨАТ Value-added tax (VAT)	1991.08.01	18%	
75	Philippines	НӨАТ *Value-added tax (VAT)*	1988.01.01	12%	
76	Poland (EU)	НӨАТ *Value-added tax (VAT)*	1993.07.05	23%	Бууруулсан 5-8%
77	Portugal (EU)	НӨАТ *Value-added tax (VAT)*	1986.01.01	23%	Бууруулсан 6-13%
78	Puerto Rico	Худалдааны болон ашиглалтын татвар *Sales and use tax (SUT)*	2006.11	7%	
79	Romania (EU)	НӨАТ *Value-added tax (VAT)*	1993.07.01	24%	Бууруулсан 5%-9%
80	Russian Federation	НӨАТ *Value-added tax (VAT)*	1991.12.06	18%	Бууруулсан 10%
81	Rwanda	НӨАТ *Value-added tax (VAT)*	2001.01.01	18%	
82	Serbia	НӨАТ *Value-added tax (VAT)*	2005.01.01	20%	Бууруулсан 8%
83	Singapore	Бараа ажил үйлчилгээний татвар *Goods and services tax (GST)*	1994.04.01	7%	
84	Sint Maarten	Орлогын татвар *Revenue tax (RT)*	1997.01.01	5%	
85	Slovak Republic (EU)	НӨАТ *Value-added tax (VAT)*	1993.01.01	20%	
86	Slovenia (EU)	НӨАТ *Value-added tax (VAT)*	1999.07.01	20%	Бууруулсан 8.5%
87	South Africa	НӨАТ *Value-added tax (VAT)*	1991.09.30	14%	
88	Spain (EU)	НӨАТ *Value-added tax (VAT)*	1986.01.01	21%	Бууруулсан 4-10%
89	Sweden (EU)	НӨАТ *Value-added tax (VAT)*	1969.01.01	25%	Бууруулсан 6-12%
90	Switzerland	НӨАТ *Value-added tax (VAT)*	1995.01.01	8%	Бууруулсан 2.5-3.8%
91	Taiwan	Бизнесийн үйл ажиллагаа эрхэлсний татвар *Business tax* Бизнесийн орлогын татвар Gross Business *Receipt Tax [GBRT])*	1931.06.13	0-5% 0.1-25%	2011.10-р сард уг эрх зүйн актаа шинэчлэн найруулгаар баталсан
92	Tanzania	НӨАТ *Value-added tax (VAT)*	1998.07.01	18%	
93	Thailand	НӨАТ *Value-added tax (VAT)*	1992.01.01	7%	2014.01.01-ээс уг татварын хэмжээгээ 10% болгохоор шийдвэрлэсэн.

94	Trinidad and Tobago	НӨАТ *Value-added tax (VAT)*	1990.01.01	15%	
95	Tunisia	НӨАТ *Value-added tax (VAT)*	1998.06.02	18%	Бууруулсан 6%-12%
96	Turkey	НӨАТ *Value-added tax (VAT)*	1984.11.02	18%	Бууруулсан-8%
97	Uganda	НӨАТ *Value-added tax (VAT)*	1996.07.01	8%	Бууруулсан 18%
98	Ukraine	НӨАТ *Value-added tax (VAT)*	1992.01.01	20%	2014.01.01-нээс уг татварын хэмжээгээ 17% болгохоор шийдвэрлэсэн.
99	United Kingdom (EU)	НӨАТ *Value-added tax (VAT)*	1973.04.01	20%	Бууруулсан 5%
100	Uruguay	НӨАТ *Value-added tax (VAT)*	1972.12.29	22%	Бууруулсан 10%
101	Venezuela	НӨАТ *Value-added tax (VAT)*	1993.10.01	8-16.5%	
102	Vietnam	НӨАТ *Value-added tax (VAT)*	1999.01.01	10%	Бууруулсан 5%
103	Zambia	НӨАТ *Value-added tax (VAT)*	1995.07	16%	
104	Zimbabwe	НӨАТ *Value-added tax (VAT)*	2004.01.01	15%	

Эх сурвалж: Worldwide VAT, GST and sales tax guide 2013

* * *

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Сангийн сайдын 2009 оны 12 дугаар сарын 15.-ны өдрийн 283 тоот тушаалын хавсралт “Нэмэгдсэн өртгийн албан татварын хасалт хийх, буцаан олгох, тэдгээрийг нягтлан бодох бүртгэлд тусгахтай холбогдсон харилцааг зохицуулах журам”.
- Монгол Улсын НӨАТ-ын тухай хуулийн хэрэгжилт, цаашдын чиг хандлага. О.Цогт. Уул уурхайн салбарын институцийг бэхжүүлэх техник туслалцааны төсөл. УБ., 2011.08.10. Эх сурвалж: www.mta.mn.
- СЯ-ны ТБЗГ-ын статистик мэдээ. Эх сурвалж: www.mof.gov.mn
- СЯ-ны ТБЗГ-ын www.iltod.gov.mn вэб сайт, 2011 он.
- Татварын ерөнхий газрын мэдээллийн эмхэтгэл 2011 он www.mta.mn
- Dictionary of taxation terms /English-Russian-German-French/ TACIS, First Edition, 1996.
- Г.Цэрэндагва “Эдийн засгийн ухаан”. УБ., 2013 он.
- ТЕГ, МУИС-ХЗС, ШУА “Монгол Улсын албан татварын эрх зүй” УБ 2009 он.
- Борлуулалтын татвар ба НӨАТ-ын судалгаа http://www.iltod.gov.mn/?p=1956
- Katrhryn James, 2011, Exploring the origin and global rise of VAT, 15, Vat Reader, Tax analysts.
- Indonesia VAT Law.
- Налоговый кодекс РК.
- ftnref1 Wet op de omzetbelasting 1968 – Wet OB. Эх сурвалж: http://wetten.overheid.nl/BWBR0002629/geldigheidsdatum_04-07-2013
- Налоговый кодекс Российской Федерации (НК РФ), Раздел VIII. Федеральные налоги, Глава 21. Налог на добавленную стоимость.
- Worldwide VAT, GST and sales tax guide, 2013.
- The SII Commissioner Julio Pereira, 2011, 2010 Official Accounts address, Santiago.
- http://www.government.nl/issues/taxation
- http://www.ey.com/Publication/vwLUAssets/2013-worldwide-VAT-GST-and-sales-tax-guide/$FILE/2013-worldwide-VAT-GST-and-sales-tax-guide.pdf
- John Brondolo, Ron McMorran, Robin Adair, 1999, Mongolia: Improving the design and administration of the VAT IMF-Worldbank.